



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/396

Булган сум

“Сансар марафон 2025” гүйлтийн тэмцээнийг  
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хүн сансарт ниссэний 44 жилийн ой, Булганчуудын бахархлын өдрийг тохиолдуулан гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдах “Сансар марафон 2025” тэмцээнд 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны  
 06 дугаар сарын 09-ны/ний өдрийн  
 А/396 дугаар захирамжийн хавсралт

Сансар марафон 2025” гүйлтийн тэмцээний шагналын төсөв

Д/д	Тэмцээний төрөл	1-р байр	2-р байр	3-р байр	4-8-р байр		Дүн
					6	7	
1	2	3	4	5	6	7	8
1	21 км эр 18-45 нас	500,000	300,000	200,000	4 байр	100,000	1,340,000
					5 байр	80,000	
					6 байр	60,000	
					7 байр	50,000	
					8 байр	50,000	
2	21 км эм 18-45 нас	500,000	300,000	200,000	4 байр	100,000	1,340,000
					5 байр	80,000	
					6 байр	60,000	
					7 байр	50,000	
					8 байр	50,000	
3	21 км эр 46 дээш нас	300,000	200,000	150,000	4 байр	100,000	990,000
					5 байр	80,000	
					6 байр	60,000	
					7 байр	50,000	
					8 байр	50,000	
4	21 км эм 46 дээш нас	300,000	200,000	150,000	4 байр	100,000	990,000
					5 байр	80,000	
					6 байр	60,000	
					7 байр	50,000	
					8 байр	50,000	
5	5000 м 18-34 эр	120,000	100,000	80,000	4 байр	50,000	460,000
					5 байр	40,000	
					6 байр	30,000	
					7 байр	20,000	
					8 байр	20,000	
6	5000 м 18-34 эм	120,000	100,000	80,000	4 байр	50,000	420,000
					5 байр	40,000	
					6 байр	30,000	
<b>Нийт дүн</b>						<b>6,000,000</b>	